

**Олон улсын тээвэрлэлтийн үйлчилгээ  
Сэдэв: Авто замын тээвэрлэлт**

**Улаанбаатар хот  
2018**

## **АГУУЛГА**

1. Авто замын тээвэрлэлтийн онцлог, давуу болон сул талууд.....	3
2. Олон улсын авто замын тээвэрлэлтийн хэлбэр.....	5
3. Олон улсын авто замын тээвэрлэлтийн эрх зүйн зохицуулалт .....	7
Хүснэгт. Авто тээврийн салбарын үндсэн үзүүлэлт .....	8
4. Эх сурвалжийн жагсаалт .....	9

## 1. Авто замын тээвэрлэлтийн онцлог, давуу болон сул талууд

Олон улсын авто замын ачаа тээвэрлэлт гэдэг нь төрөл бүрийн ачаа тээх зориулалт бүхий авто машиныг ашиглан 2 буюу түүнээс дээш улсын нутаг дэвсгэрийг дамжин, нийлүүлэгчээс хүлээн авагчид ачаа барааг хүргэж өгөх үйл ажиллагаа юм.



Авто замын тээвэр нь хаалганаас хаалганд хүртэл тээвэрлэлт хийх чадвартай, өөрөөр хэлбэл ачилт буулгалт хийх тусгай буудал, боомт шаардаад байдаггүй, нийлүүлэгчийн үйлдвэрийн агуулахаас хэрэглэгчид шууд хүргэж өгөх боломжтой байдгаараа тээврийн бусад хэлбэрээс давуу талтай.

Авто замын тээвэрлэлтийг уян хатан хөдөлгөөнтэй, түргэн шуурхай, ойрын зайн тээвэрлэлтэнд төмөр замаас илүү эдийн засгийн хувьд ашигтай, ойрын зайнд тээвэрлэлт хийдэг учир бараа бүтээгдэхүүнд эвдрэл гэмтэл бага гардаг гэж үздэг.



Авто замын тээвэрлэлтийн **давуу тал нь:**

- Хаалганаас хаалганд буюу нийлүүлэгчийн үйлдвэрийн агуулахаас хэрэглэгч хүртэл тээвэрлэлт хийх боломжтой, уян хатан.
- Бараа, бүтээгдэхүүний эвдрэл, алдагдал бага.
- Ойрын зайд бараа бүтээгдэхүүнийг хямд өртгөөр тээвэрлэх боломжтой.
- Тээвэрлэлтийг хялбархан зохион байгуулах боломжтой.
- Тээвэрлэлтийн явцад сэлгэн ачилт бага. Сав баглаа боодлын хувьд хялбар, энгийн.
- Тусгайлсан буудал, ачиж буулгах цэг байгуулах шаардлагагүй.
- Цаг агаарын нөлөөлөл бага.

Авто замын тээвэрлэлтийн **сул тал нь:**

- Тээврийн зардал өндөр.
- Нэг удаа тээвэрлэх хэмжээ бага.
- Зам тээврийн осол гарах магадлал их.

Авто замын тээвэрлэлтийг харьцангуй хялбар зохион байгуулах боломжтой бөгөөд ялангуяа жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн хувьд тусгайлан тоногдсон ачих буудал байхгүй ч үйлдвэрийн агуулахаасаа ердийн байдлаар ачилт хийх боломжтой.

Авто тээврийн тарифыг улс орнуудын холбогдох байгууллагууд өөрсдөө тогтоодог учраас орон бүрт харилцан адилгүй байдаг. Тариф тогтоохдоо ачааг тээвэрлэх замын урт, ачааг тээвэрлэх тусгай нөхцөл шаарддаг эсэх, ачааны сав баглаа, боодол, аюулгүй байдлын зэрэглэл зэргээс хамааруулан нэмэгдэл эсвэл хөнгөлөлт үзүүлдэг байна.

## 2. Олон улсын авто замын тээвэрлэлтийн хэлбэр

Орчин цагт дэлхийн бүх улс орон автомашиныг төрөл бүрийн бараа тээвэрлэхэд ашиглаж байна. Автомашиныг хувийн хэрэгцээнээс авахуулаад томоохон уул уурхайд хүртэл өргөн хэмжээгээр ашиглаж байна. Олон улсын авто замын тээвэрлэлтийн зохион байгуулж буй хэлбэрээс хамааруулан дараах байдлаар ангилна. Үүнд:

- **Ачаа барааг цуглуулж тээвэрлэх буюу цуглуулбар тээвэрлэлт:** Ачаа барааг илгээгчдээс цуглуулан авч ачиж буулгах цэг хүртэл, ачиж буулгах цэгээс ачаа барааг хүлээн авагчдад хүлээлгэн өгдөг тээвэр
- **Шууд бус тээвэрлэлт:** Ачиж буулгах цэгээс очих газрын ачиж буулгах цэг юм уу эсвэл үйлчлүүлэгчийн гэрт нь холын зайны овор ихтэй том барааг хүргэж өгдөг. Дунд эсвэл том оврын тээврийн хэрэгсэл шаарддаг.
- **Чиглэлт тээвэрлэлт:** Урьдаас тогтоосон чиглэлийн дагуу тодорхой төлөвлөгөөтэй хийж буй тээвэрлэлт.
- **Хүргэж өгөх тээвэрлэлт:** Ачаа барааг хүлээн авагчид дамжуулан өгдөг тээвэр. Ачиж буулгах цэгээс эсхүл бусад тээврийн хэрэгслээс дамжуулан тээвэрлэж болно.

Сүүлийн үед ачааг олон төрлийн тээврийн хэрэгсэл ашиглан чингэлгээр тээвэрлэдэг холимог тээвэрлэлт нэмэгдсэнтэй холбоотойгоор олон улсын тээвэрлэлтэд эзлэх авто тээвэрлэлтийн гүйцэтгэх үүрэг улам бүр өссөөр байна.

Авто замын сүлжээ сайн хөгжсөн, газар нутаг багатай, нэгдмэл гаальтай Европын холбооны улсуудад авто тээвэр дангаараа олон улсын тээвэрлэлтийг гүйцэтгэж байгаа бол Ази номхон далайн орнуудад далайн болон төмөр замын боомтод ачааг хүргэж өгөх, тэндээс ачааг хүлээн авагчид хүлээлгэн өгөх зэргээр зайлшгүй олон улсын тээвэрлэлтийн үе шатуудад ийм төрлийн тээвэрлэлт оролцож байгааг тэмдэглэх нь зүйтэй.

### ***Дэлхийн хамгийн том ачааны машин БелАЗ 75710***

Өнөө цагт дэлхийн хамгийн том, хамгийн их даацтай уул уурхай өөрөө буулгагч машины дээд амжилтыг 2013 оны намар тогтоосон. Энэ аварга машин бол Беларусийн алдарт "БелАЗ" компанийн "БелАЗ 75710" хэмээх загвар юм. Дэлхийн хамгийн том өөрөө буулгагч буюу уул уурхайн тээвэрлэгч болсон "БелАЗ 75710" машин 450 тонн даацтай болсон бөгөөд өмнөх амжилтыг 87 тонноор давуулсан байна.

Дэлхийн хамгийн том машиныг хийх 644 сая ам.долларын төслийн хүрээнд "БелАЗ 75710" загварын эхний гурвыг хийсэн бөгөөд анхны хэрэглэгч нь Кузбассын уурхай болсон байна. 2014 онд Гиннесийн дээд амжилтын номд бүртгэгджээ.

- ✚ Өндөр: 8.16 м
- ✚ Өргөн: 9.87 м
- ✚ Урт: 20.6 м
- ✚ Ачаа өргөх үеийн өндөр:
- ✚ Тэнхлэгийн тоо: 2
- ✚ Тэнхлэг хоорондын зай: 8 м
- ✚ Өөрийн жин: 360 тн
- ✚ Нийт жин: 596.9 тн
- ✚ Даац: 500 шот.тн буюу 450 тн
- ✚ Дээд хурд: 64км/цаг
- ✚ Дугуйны хэмжээ: 59/80 R63
- ✚ Түлшний савны багтаамж: 4,732 литр
- ✚ Хөдөлгүүр: тус бүр нь 2300 морины хүчтэй хос Siemens MMT 500 хөдөлгүүртэй.



### **3. Олон улсын авто замын тээвэрлэлтийн эрх зүйн зохицуулалт**

Зам харилцаа сайжирч, авто тээвэрлэлтийг зохицуулах олон улсын эрхзүйн зохицуулалт улам бүр боловсронгуй болж байгаатай холбоотойгоор автомашиныг ашиглан улс дотроо дотоодын тээвэрлэлтэд болон улс дамнан гадаад худалдаанд ч ашиглаж байна.

Монгол улс авто замын тээвэрлэлттэй холбоотой дараах олон улсын хэлэлцээрүүдэд нэгдэн орсон байна. Үүнд:

- Улс хоорондын авто замаар ачаа тээвэрлэх гэрээний тухай конвенци (1956.05.19)
- Замын хөдөлгөөний тухай конвенци (1968.11.08)
- Тир карнейн хүрээнд барааг олон улсын хэмжээнд тээвэрлэх тухай конвенци

Авто замын тээврээр тээвэрлэж байгаа ачааг түргэн шуурхай нэвтрүүлэх зорилгоор Тир карнейн хэлбэрийн доорх барааг тээвэрлэх болсон. Ийм хэлбэрээр хийгдэж байгаа тээвэрлэлтийн арга нь 1970-аад оноос авто замын тээвэрлэлтэд хүнд даацын буюу 10, 20, 40 тоннын контейнерүүд тээвэрлэдэг автомашинуудыг өргөнөөр ашиглагдаж эхэлсэнтэй холбоотойгоор үүссэн. Тир карнейн хэлбэрээр тээвэрлэгдэж байгаа ачаа нь дамжин өнгөрч буй улс орнуудын хилийг гаалийн үзлэг шалгалтгүй нэвтэрдэг. Учир нь илгээгч орны гаалийн байгууллагад үзлэгт орж битүүмжлэгдээд хүлээн авагч орны гүний гаальд үзлэг шалгалтад ордог нь дамжин өнгөрөх орнуудын гаалийн шалгалтуудыг алгасаж цаг хугацаа, засаг захиргааны зүгээс ирж болзошгүй хүнд суртлыг тойрон гарах боломжийг олгодог.

Монгол улсын гадаад дотоод тээвэрлэлтийг гүйцэтгэдэг нэг гол тээврийн хэрэгслийн төрөл бол авто тээвэрлэлт юм. Сүүлийн жилүүдэд томоохон уул уурхайн орд газрууд нээгдсэн нь экспортын чиглэлтэй авто тээвэрлэлтийн хэмжээ өсөх гол үндсэн нөхцөл болж байна. Хүснэгт 1-ээс харахад авто тээвэрлэлтийн хэмжээ өсөж байгаа боловч зөвхөн уул уурхайн тухайлбал нүүрс, хүдрийн баяжмалын экспортын тээвэрлэлтийн дийлэнх байна.

Экспортын тээвэрлэлтийн багахан хувийг хил орчмын тээвэрлэлт эзэлж байна. Энэ нь дотоодын замын сүлжээний хөгжил, дотоодын үйлдвэрлэлийн бараа бүтээгдэхүүний гадаад зах зээл дэх эрэлт, өрсөлдөх чадвар хангалтгүй байгаатай холбоотой экспортын тээвэрлэлтэд бэлэн бүтээгдэхүүний эзлэх хувь бага байна.

### **Хүснэгт. Авто тээврийн салбарын үндсэн үзүүлэлт**

Үзүүлэлт	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Тээсэн ачаа, мянган тонн	12,610.2	25,635.3	30,195.1	21,321.9	23,514.2	13,043.7	20,406.2	31,212.9
Ачаа эргэлт, сая тонн километр	1,834.	4,910.3	3,503.9	2,555.8	4,936.4	2,374.	4,236.2	5,661.3

Эх үүсвэр: Үндэсний статистикийн газар, 1212.mn

Тээвэрлэлтийн хэмжээ бага учраас манай улсад олон улсын чанартай тээвэрлэлт хийх чадвартай компаниуд өсч хөгжихгүй байгаа байдал харагдаж байна. Үүний сацуу БНХАУ-ын санаачилсан “Талын зам” төсөл зэрэг олон улсын болон бүс нутгийн шинж чанартай санал санаачлага гарч байгаа нь авто тээвэрлэлтийн хэтийн төлөвийг өөдрөгөөр төсөөлөх боломжтой болгож байна.

Манай улсын нутаг дэвсгэрээр дайран өнгөрдөг олон улсын чанартай зам, сүлжээ бий болох нь экспортын үйлдвэрлэл эрхлэгчдийн хувьд хөрш орнууд болон тэдний нутаг дэвсгэрээр дамжин өөр бусад оронд хүссэн хэмжээ, давтамжаар ачаа бараагаа тээвэрлэх үүд хаалга нээгдэх болно.



## 4. Эх сурвалжийн жагсаалт

1. Батнасан.Н., (2003), “Гадаад худалдаа: Үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, эрх зүйн зохицуулалт”, хуудас 220-221.
2. Монгол банк, Бодлогын саналын судалгаа: Гадаад худалдааны тээвэр, логикийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудал, Улаанбаатар 2012
3. <https://www.slideshare.net/ssuser052fe8/ss-48221300>
4. Авто тээврийн тухай хууль:  
<http://www.legalinfo.mn/law/details/29?lawid=29>